



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Л.БАЯРМАНДАЛ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.02.23 № 07/334

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ашигт малтмал, газрын тосны газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Ашигт малтмал, газрын тосны газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,905,896.8 мянган төгрөгийн зөрчил илэрч, улсын төсвийн орлого дутуу бүрдүүлж, төвлөрүүлсэн, орлогын анхан шатны бүртгэл, ногдуулалтад тавих хяналт сул, сургалтын төлбөрийг суралцагч бүрээр тооцоо үүсгэж хяналт хэрэгжүүлээгүй байгаа нь шинж чанарын хувьд материаллаг, дангаараа буюу эсвэл нийтээр санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.2, 41 дүгээр зүйлийн 41.2.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 13 дугаар зүйлийн 13.3, 13.4 дэх заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг цахим /tender.gov.mn болон mram.gov.mn/ системд бүрэн нэвтрүүлж зохион байгуулснаар төрийн үйлчилгээг ил тод болгон, тайлант онд 2.3 сая гектар бүхий 2450 талбайг зарласнаас 1.1 сая гектар бүхий 209 зөвшөөрөл олгосон байна.

Аудитын гол асуудал

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт улсын төсөвт төвлөрүүлэх болон үйл ажиллагааны орлогыг мөнгөн сууриар бүртгэхээр тусгасан, сургалтын урамшууллын хөрөнгийг хянаж бүртгэх талаар тусгаагүй зэрэг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандарттай нийцээгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Ашигт малтмал, газрын тосны газар нь 2023 онд 2 зорилгын хүрээнд 25 зорилт, 70 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн 91.3 хувийн биелэлттэй гэж тайлагнасан байна.

Нийт арга хэмжээний 40 арга хэмжээ 100 хувь, 26 арга хэмжээ 70-90 хувь, 3 арга хэмжээ 50 хувийн хэрэгжилттэй гэж тайлагнасан бөгөөд 1 арга хэмжээ хэрэгжээгүй байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

